

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГАХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

/2021 оны жилийн эцсийн байдлаар/

| № | ЗГҮАХ-т тусгагдсан зорилт | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Нийт хөрөнгийн хэм-жээ, 2021-2024 (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр) | | |
|---|---|--|------------------|---|--|--------------|--|----------------|---|
| | | | | | | | 2021 он | | |
| | | | | | | | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв, сая.төг | Хүрсэн түвшин, үр дүн |
| ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | | | | | | | | | |
| 1. Олон улсын нислэгийг өргөжүүлэх, аяллын дугаар хуваах зэргээр нислэгийн давтамж, чиглэлийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | |
| 1 | 3.6.4. Агаарын тээврийн либералчлалыг үргэлжлүүлж, нислэгийн тоо чиглэлийг нэмэгдүүлэн, орон нутгийн нисэх буудлуудын ашиглалтыг сайжруулна | 1. Агаарын харилцааны зохицуулалтыг сайжруулж, агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрүүд -ийг байгуулна. | 2021-2024 | Улсын төсөв /өөрийн орлого/ Зарцуулсан хөрөнгө 2020 он-2021 он: | 2,300.0 | - | 4 улстай агаарын харилцааны хэлэлцээр байгуулж, 2 улстай нислэгийн цэг, давтамжийг нэмэгдүүлсэн байна. | 700.0 | Азербайжан Улс: Азербайжаны талтай үзэглэсэн “Агаарын харилцааны хэлэлцээр”-ийг байгуулах бэлтгэл ажил хангагдсан боловч хэлэлцээрт гарын үсэг зурах ажил цар тахлын улмаас хойшлогдсон. Иймд хэлэлцээрийг дипломат шугамаар ноот бичиг солилцож байгуулах саналыг Азербайжаны талд ГХЯ-аар дамжуулан хүргүүлсэн. Гэвч айлын талаас цар тахлын нөхцөл байдал намжсаны дараа өндөр хэмжээний айлчлалын үеэр хэлэлцээр байгуулах санал ирүүлсэн. Ерөнхий сайдын 2020.09.22-ны 51 дүгээр захирамжаар тус хэлэлцээрт Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт олгосон. Азербайжаны талаас ирүүлсэн 2018 онд үзэглэсэн хэлэлцээрийн төсөлд өөрчлөлт оруулах саналыг 2021 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 09/3487 тоот албан бичгээр ЗТХЯ тус байгууллагад ирүүлсний дагуу холбогдох өөрчлөлтийг оруулж, 2021 оны 8 дугаар |

| | | | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|--|--|
| | | | | | | | | <p>сарын 19-ний өдрийн 01/1364 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.</p> <p>Грек Улс: Грекийн талтай үзэглэсэн “Агаарын харилцааны хэлэлцээр”-ийг байгуулах бэлтгэл ажил хангагдсан боловч хэлэлцээрт гарын үсэг зурах ажил цар тахлын улмаас хойшлогдсон. Иймд хэлэлцээрийг дипломат шугамаар ноот бичиг солилцож байгуулах саналыг Грекийн талд ГХЯ-аар дамжуулан хүргүүлсэн. Грекийн талаас БНХАУ-д суугаа 2 улсын сайд хэлэлцээрийг баталгаажуулах боломжтой гэсэн хариуг Грекийн талаас 2021 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр Е-мэйл ирүүлсэн. Түүний дагуу хэлэлцээрийн төслийг монгол, грек, англи 3 хэл дээр бэлтгэж, БНХАУ-д суугаа хоёр улсын элчин сайдуудаар албажуулан хэлэлцээрт гарын үсэг зурахаар ГХЯ-тай хамтран ажиллаж байна. Ерөнхий сайдын 2020.09.22-ны 52 дугаар захирамжаар тус хэлэлцээрт Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт олгосон.</p> <p>Япон Улс: ЗТХЯ-наас ирүүлсэн чиглэлийн дагуу Япон Улсын Иргэний нисэхийн товчоотой хоёр улсын хооронд долоо хоногийн нислэгийн давтамж 30 байхаар тохиролцохоор хэлэлцэж Санамж бичгийн төслийг Японы талтай хамтран боловсруулж холбогдох чиглэл, зөвшөөрөл авахаар 2021 оны 7 дугаар сарын 27-ны өдөр 01/1214 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн бөгөөд ЗТХЯ-наас 2021 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 09/3697 тоот албан бичгээр давтамж, багтаамжийг уялдуулах тухай чиглэл ирүүлсний дагуу Японы талтай дахин хэлэлцээ хийж байна.</p> <p>Испани Улс: Испанийн Вант Улстай “Агаарын харилцааны тухай хэлэлцээр”</p> |
|--|--|--|--|--|--|--|--|--|

| | | | | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|--|--|---|
| | | | | | | | | | <p>байгуулахаар хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцож 2021 оны 7 дугаар сарын 27-ны өдөр үзэглэсэн.</p> <p>Оросын Холбооны Улс: ОХУ-ын Тээврийн яамтай харилцан солилцож, ОХУ-ын Кызыл, Монголын Улаангом хотыг нисэн очих цэгээр нэмж, нислэгийн чиглэл нэмсэн.</p> <p>БНСУ: Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын агаарын харилцааны ээлжит уулзалт, хэлэлцээг 2021 оны 8 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд Сүүл хотноо зохион байгуулж, Улаанбаатар-Сүүл/Инcheon/-Улаанбаатар чиглэлд Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбоо /IATA/-ны 2022 оны зуны цагийн хуваариас эхлэн 6-9 дүгээр сарын оргил ачааллын үед хоёр талаас тус бүр долоо хоногт 5000, Монголын тал 20, Солонгосын тал 18 давтамжтай, 5-10 дугаар сард 2500 суудлын багтаамж буюу долоо хоногт Монголын тал 11, Солонгосын тал 9 давтамжаар нислэг гүйцэтгэх одоогийн тохиролцоог хэвээр хадгалахаар тохиров.</p> <p>БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконг: Улаанбаатар-Хонконгийн чиглэлийн нислэгийн давтамжийг долоо хоногийн 11 байгааг 15 болгосон.</p> <p>Индонези Улс: Индонезийн талаас Засгийн газар хоорондын Агаарын харилцааны хэлэлцээр байгуулах саналыг 2021 оны 8 дугаар сарын 6-ны өдөр ирүүлсэн. Монголын талын АХХ-ийн төслийг 2021 оны 8 дугаар сарын 26-ны өдөр Индонезийн талд хүргүүлсэн. Индонезийн талаас өөрийн АХХ-ийн төслийг 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр ирүүлсэн бөгөөд талууд АХХ төсөл тохиролцохоор хамтран ажиллаж байна.</p> |
|--|--|--|--|--|--|--|--|--|---|

| | | | | | | | | | |
|---|--|--|-----------|---|----------|----------------------|--------------------------|----------|--|
| 2 | | 2. "Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр, "Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ | 2021-2023 | Улсын төсөв /өөрийн орлого/ Зарцуулсан хөрөнгө 2020 он 547.8 2021 он: | 51,400.0 | Хөтөлбөр батлагдсан. | Хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 12,850.0 | <p>Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр: Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг ЗТХСайдын зөвлөлийн 2021.04.02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, эрчимжүүлэх арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн. Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын 2021.03.26-ны өдрийн "Иргэний нисэхийн үндэсний төвийн 2021 оны орлого, зардлын төлөвлөгөөг батлах тухай" А/42/44 дугаар хамтарсан тушаалаар орон нутгийн нислэгт 900.0 сая төгрөгийн татаас олгохоор баталсан. Улаанбаатар-Баянхонгор-Улаанбаатар чиглэлд 2021 оны 4 дүгээр улирлын байдлаар 16 удаагийн нислэгээр 878 зорчигч, 55%-ийн дундаж суудал ашиглалттайгаар, 50%-ийн хямдралтай үнээр тээвэрлэсэн байна. Улаанбаатар-Баруун-Урт, Улаанбаатар-Тосонцэнгэл, Улаанбаатар-Ховдын Булган чиглэлд нөхөн олговортой нислэг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтыг 2021.09.14-нд зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулахаар бэлэн болсон байсан ч ЗГ-ын тогтоолоор хөтөлбөр хүчингүй болсон тул гэрээ байгуулаагүй. Хөтөлбөрийн хэрэгжилт энэ оны жилийн эцсийн байдлаар урьдчилсан тогтоосон шалгуур үзүүлэлтээр дүгнэхэд 43%-тай, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 59%-ийн хэрэгжилттэй.</p> <p>Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр: Ховд аймгийн Чандмань, Өвөрхангай аймгийн Хужирт, Өвөрхангай аймгийн Цагааннуур сумдад бага оврын агаарын хөлгийн хөөрч буух зурвас байгуулахаар 52,3 сая төгрөгийн санхүүжилтийг Зам, тээврийн</p> |
|---|--|--|-----------|---|----------|----------------------|--------------------------|----------|--|

| | | | | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|--|--|--|
| | | | | | | | | | <p>хөгжлийн сайд, Сангийн сайдын 2021.03.26-ны өдрийн “Иргэний нисэхийн үндэсний төвийн 2021 оны орлого, зардлын төлөвлөгөөг батлах тухай” А/42/44 дугаар хамтарсан тушаалаар Иргэний нисэхийн үндэсний төвийн 2021 оны өөрийн орлогоос санхүүжүүлэхээр баталсан.Ховд аймгийн Чандмань, Өвөрхангай аймгийн Хужирт, Хөвсгөл аймгийн Цагаан нуур сумдад бага оврын агаарын хөлгийн хөөрч буух зурвасын тэмдэг тэмдэглэгээг байршуулж, баталгаажуулсан. 2021 онд бага оврын агаарын хөлгийн 87 хөөрч, буух зурвасын байршлыг тогтоохоор төлөвлөснөөс 2021.10.10-ны байдлаар 61 байршилд хөөрч, буух зурвасын цэгийг сонгон хэмжилт хийж, координатыг баталгаажуулаад байна. Хөтөлбөрийн хэрэгжилт энэ оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 82.8%-тай байна. Урт хугацаатай хөнгөлөлттэй зээл, бусад төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх болон хөрөнгө оруулалтыг дэмжсэн эрх зүйн орчныг судалж, цаашид авах арга хэмжээг тодорхойлохоор судалгаа хийсэн. Ерөнхий зориулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын зардлын төслийг боловсруулан, 2021 оны 5 дугаар сарын 19-нд ЗТХЯ-нд хүргүүлсэн. Булган, "Буянт-Ухаа", Мөрөнд агаарын хөлгийн шатахуун хангамжийн төв байгуулахад 309 сая төгрөг, 15 байршилд бага оврын агаарын хөлөг хөөрч, буух зурвас байгуулах тэмдэг, тэмдэглэгээний зардалд 261 сая 300 мянган төгрөгийг ИНҮТ-ийн 2022 оны орлого, зардлын төсвийн төсөөлөл, хөрөнгө оруулалтын жагсаалтад саналаа тусгасан. Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх</p> |
|--|--|--|--|--|--|--|--|--|--|

| | | | | | | | | | |
|---|--|--|-----------|--|----------|------------------------------|-----------------------------------|--------------------------------|--|
| | | | | | | | | | хөтөлбөр"-ийг хүчингүй болгосон тул хөтөлбөрийн хэрэгжилт зогссон. |
| 3 | | 3.Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийг барьж, дуусган ашиглалтад оруулна. | 2020-2021 | Улсын төсөв Зарцуулсан хөрөнгө 2011-2018 онд 15,400.0 2020 он-2021 он: | 3,900.0 | Барилгын ажлын гүйцэтгэл 90% | Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь | 3,900.0 | Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн оффисын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2020 оны жилийн эцсийн байдлаар 90%-тай. |
| 4 | | 4.Агаарын навигацийн үйлчилгээний техник технологийг шинэчилнэ. | 2021-2024 | Улсын төсөв /өөрийн орлого/ Зарцуулсан хөрөнгө 2020 он-2021 он: | 35,080.0 | | АТМ тогтолцоог шинэчилнэ. | 20,920.0 3.915.6 | АТМ тогтолцоог шинэчлэх ажилд нийтдээ 39.195 тэрбум төгрөг зарцуулна. АТМ тогтолцоог шинэчлэх буюу бүсийн нислэгийн хөдөлгөөний шинэ бүсийн төвийн агаарын навигацийн үйлчилгээний тоног төхөрөөмжийг цогц байдлаар шинэчлэх ажлын хүрээнд дараах 4 иж бүрдэл систем, тоног төхөрөөмжийг худалдан авч суурилуулахаар төлөвлөсөн. Үүнд: <ul style="list-style-type: none"> ❖ Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын автоматжуулалтын систем ❖ Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын дуу дүрс, өгөгдлийн синхрон бичлэгийн систем ❖ Агаар-газрын дуун холбооны сувгуудын холболт, удирдлагын зангилаа төхөрөөмж /VCCS/": Агаар-газрын дуун холбооны сувгуудын холболт, удирдлагын зангилаа төхөрөөмж /VCCS/-ийг нийлүүлэх, суурилуулах ажлыг 2019 онд гүйцэтгэсэн./100%/ |

| | | | | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|--|--|---|
| | | | | | | | | | <p>❖ Бүсийн нислэгийн хөдөлгөөн удирдлагын шинэ төвийн IP, VPN технологид суурилсан дамжуулах байгууламжийг шинэчлэх</p> <p>2021 онд Бүсийн нислэгийн хөдөлгөөн удирдлагын шинэ төвийн IP, VPN технологид суурилсан дамжуулах байгууламжийг шинэчлэх ажилд хийгдэнэ. Иргэний нисэхийн үндэсний төвийн 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд “Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын шинэ төвийн агаарын навигацийн үйлчилгээний тоног төхөөрөмж, систем” байгуулахад 3.915.6 сая төгрөг тусгагдсан бөгөөд батлагдсан төсвийн хүрээнд энэ онд агаарын навигацийн үйлчилгээний мэдээлэл дамжуулах IP технологид суурилсан сансрын холбооны төв болон алсын станцыг нийлүүлэх болон Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвийн VPN технологид суурилсан шилэн кабелийн дамжуулах сүлжээний тоног төхөөрөмжүүдийг нийлүүлэх, суурилуулах ажлыг гүйцэтгэнэ. Агаарын навигацийн үйлчилгээний мэдээлэл дамжуулах IP технологид суурилсан сансрын холбооны систем нийлүүлэх ИНЕГ/202104013 тендерийн гүйцэтгэгчээр “АЙ ТИ ЗОН ХХК-тай 202.09.08-нд гэрээ байгуулсан. Гэрээний дагуу 2022.01.07-ны дотор тоног төхөөрөмжийг нийлүүлнэ. 3.915.6 сая төсөвт өртөгтэй. Агаарын навигацийн нэгдсэн VPN сүлжээ зохион байгуулахтай холбоотой дамжуулах байгууламжийн шинэчлэл, 14 иж бүрдэл /Даланзадгад, Баянхонгор, Булган, Баруун-Урт, Өндөрхаан, Чойбалсан, Сайншанд, Арвайхээр, Улаангом, Алтай, Доной, Мөрөн, Ховд, Мандалговь/ ИНЕГ/202104021 тендерийн гүйцэтгэгчээр “АЧ СВС” ХХК сонгон шалгарч, гэрээг</p> |
|--|--|--|--|--|--|--|--|--|---|

| | | | | | | | | | |
|---|--|--|-----------|---|----------|-----------------------------|---|--|--|
| | | | | | | | | | байгуулсан. Гэрээний дагуу 2021.12.24-нд тоног төхөөрөмж нийлүүлнэ. 2.000,0 сая төсөвт өртөгтэй. Иргэний нисэхийн үндэсний төвийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төсөлд “Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын шинэ төвийн агаарын навигацийн үйлчилгээний тоног төхөөрөмж, систем” байгуулахад 11.649.7 сая төгрөг тусгуулсан. |
| | 2. Ховд, Дорнод, Хөвсгөл аймгуудын нисэх буудлуудыг 4 С ангиллын олон улсын нисэх буудал болгон хөгжүүлэх төслийг эхлүүлнэ. | | | | | | | | |
| 5 | | 1.Дорнод аймгийн Чойбалсан нисэх буудлыг 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ. | 2021-2023 | Улсын төсөв, гадаадын зээл, тусламж Зарцуулсан хөрөнгө 2020 он-2021 он: | 62,000.0 | ТЭЗҮ, зураг төсөл хийгдсэн. | - | | Дорнод аймгийн Чойбалсан нисэх буудлын хөөрч буух зурвасыг шинээр барихад 50.7 тэрбум төгрөг, зорчигч үйлчилгээний барилгыг цагт 300 зорчигч хүлээн авах боломжтой болгож өргөтгөхөд 4.6 тэрбум төгрөг шаардлагатай бөгөөд санхүүжилтийг эрэлхийлж байна. Энэ төслийг АХБ-ны хөнгөлөлттэй зээлд хамруулах хүсэлтээ ЗТХЯ-наас 2021.02.06-ны өдрийн 01/84 тоот албан бичгээр АХБ-нд хүргүүлсэн. Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад Чойбалсан нисэх буудлыг 4С оруулахаар саналаа 2021.05.10-ны өдрийн 01/599 албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн боловч Сангийн яамнаас уг төслийг 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр байхгүй гэж үзэж хассан. Мөн төслийг “барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад оруулах саналыг ЗТХЯ-ны 2021.05.20-ны өдрийн 03/2181 тоот албан бичгээр Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. АХБ-ны Тээвэр, дэд бүтцийн зөвлөлтэй 2021.07.28-ны өдөр онлайнгаар уулзалт хийж, орон нутгийн нисэх буудлын хүчин чадлыг сайжруулах талаар баримталж буй бодлогыг |

| | | | | | | | | | |
|---|--|--|-----------|---|----------|----------------------------|---|----------|---|
| | | | | | | | | | танилцуулж, АХБ тус төслийг санхүүжүүлэх боломжийн талаар ярилцсан. Сангийн яамны холбогдох албан тушаалтнуудтай 2021.09.27-ны өдөр цахимаар уулзалт зохион байгуулахад Монгол Улс өрийн дээд хэмжээнд хүрсэн байгаа тул зээл авах боломжгүй талаар мэдэгдсэн. Уулзалтын үеэр олон улсын байгууллагуудаас санхүүжилт хүсэх, санхүүжүүлэх байгууллагуудаа өөрсдөө олохыг зөвлөсөн. Иймд уг зөвлөмжийн дагуу ЖАЙКА -тай уулзалт зохион байгуулах хүсэлтээ өгсөн боловч тус байгууллагаас 2023 он хүртэл хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санал авсан, энэ онд дахин санал авахгүй тул уулзалт зохион байгуулах шаардлагагүй гэж мэдэгдсэн. |
| 6 | | 2. Ховд аймгийн "Ховд" нисэх буудлыг 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ. | 2021-2023 | Улсын төсөв Зарцуулсан хөрөнгө 2020 он-2021 он: | 44,892.0 | ТЭЗҮ, зураг төсөл хийгдсэн | - | 38.280.6 | Ховд аймгийн нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөх, хүчитгэхэд 28.3 тэрбум төгрөг, цагт 300 зорчигч хүлээн авах зорчигч үйлчилгээний цогцолборыг шинээр барихад 21.6 тэрбум төгрөг шаардлагатай бөгөөд санхүүжилтийг эрэлхийлж байна. Төслийг зээл тусламж, концессын аль боломжит байдлаар хэрэгжүүлэхээр санхүүжилтийг эрэлхийлж байна. Төслийн санхүүжилтийг АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр шийдвэрлүүлэх хүсэлтийг ЗТХЯ-ны 2021 оны 01/732 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Мөн тус төслийг “барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр Төрийн өмчийн концессийн зүйлийн жагсаалтад оруулах саналыг ЗТХЯ-ны 2021.05.20-ны өдрийн 03/2181 тоот албан бичгээр Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад Ховд аймаг дахь нисэх буудлыг 4С болгох төсөл, арга хэмжээг тусгуулахаар |

| | | | | | | | | | |
|---|--|--|-----------|--|----------|--|--------------------------------|-------------------|--|
| | | | | | | | | | саналаа 2021.05.10-ны өдрийн 01/699 албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн боловч Сангийн яам уг төслийг 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр байхгүй гэж үзэж хассан. АХБ-ны Тээвэр, дэд бүтцийн зөвлөлтэй 2021.07.28-ны өдөр онлайнаар уулзалт хийж, орон нутгийн нисэх буудлын хүчин чадлыг сайжруулах талаар баримталж буй бодлогыг танилцуулж, АХБ тус төслийг санхүүжүүлэх боломжийн талаар ярилцсан. Сангийн яамны холбогдох албан тушаалтнуудтай 2021.09.27-ны өдөр цахимаар уулзалт зохион байгуулахад Монгол Улс өрийн дээд хэмжээнд хүрсэн байгаа тул зээл авах боломжгүй талаар мэдэгдсэн. Уулзалтын үеэр олон улсын байгууллагуудаас санхүүжилт хүсэх, санхүүжүүлэх байгууллагуудаа өөрсдөө олохыг зөвлөсөн. Иймд уг зөвлөмжийн дагуу ЖАЙКА -тай уулзалт зохион байгуулах хүсэлтээ өгсөн боловч тус байгууллагаас 2023 он хүртэл хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санал авсан, энэ онд дахин санал авахгүй тул уулзалт зохион байгуулах шаардлагагүй гэж мэдэгдсэн. |
| 7 | | 3.Хөвсгөл аймгийн "Мөрөн" нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн хүчитгэж олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ. | 2021-2022 | Гадаадын зээл, тусламж Зарцуулсан хөрөнгө 2020 он-2021 он: | 19,440.0 | | ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах | 540.0 18.898.9 | ИНЕГ-ын 2009 оны өөрийн орлогоос санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад тус нисэх буудлын Аэродромын ерөнхий төлөвлөгөө, ажлын зураг, төсвийг 48.0 сая төгрөг гүйцэтгэж экспертизээр баталгаажуулан хүлээн авсан. Хөвсгөл аймгийн "Мөрөн" нисэх буудлын үерийн хамгаалалтыг сэргээх, аэродромын хүчитгэл, өргөтгөлийн ажлын хяналтын төсвийг шинэчлэх ажлыг гүйцэтгүүлж, Зам, тээврийн хөгжлийн төвөөр баталгаажуулан хүлээн авсан. Шинэчилсэн төсөвт өртөг нь 18.9 тэрбум төгрөгөөр хянагдсан. "Мөрөн" |

| | | | | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|--|--|--|
| | | | | | | | | | <p>нисэх буудлын хөөрч буух зурвасыг өргөтгөн хүчитгэж олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлэхэд нийт 18.9 тэрбум төгрөг шаардлагатай. Нисэх буудлын зурвасыг өргөтгөн хүчитгэж, аэродромыг 4С болгох ажлыг гадаадын зээл тусламж эсхүл концессоор хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Төслийг “Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад оруулах саналыг ЗТХЯ-ны 2021.05.20-ны өдрийн 03/2181 тоот албан бичгээр Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. АХБ-ны Тээвэр, дэд бүтцийн зөвлөхтэй 2021.07.28-ны өдөр онлайнаар уулзалт хийж, орон нутгийн нисэх буудлын хүчин чадлыг сайжруулах талаар баримталж буй бодлогыг танилцуулж, АХБ тус төслийг санхүүжүүлэх боломжийн талаар ярилцсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад Хөвсгөл аймаг дахь нисэх буудлын хөөрч буух зурвасыг хүчитгэх ажлыг тусгуулахаар саналаа 2021.05.10-ны өдрийн 01/699 албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн боловч Сангийн яам уг төслийг 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр байхгүй гэж үзэж хассан. уг төслийг 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр байхгүй гэж үзэж хассан. Сангийн яамны холбогдох албан тушаалтнуудтай 2021.09.27-ны өдөр цахимаар уулзалт зохион байгуулахад Монгол Улс өрийн дээд хэмжээнд хүрсэн байгаа тул зээл авах боломжгүй талаар мэдэгдсэн. Уулзалтын үеэр олон улсын байгууллагуудаас санхүүжилт хүсэх, санхүүжүүлэх байгууллагуудаа өөрсдөө олохыг зөвлөсөн. Иймд уг зөвлөмжийн дагуу ЖАЙКА -тай уулзалт зохион байгуулах хүсэлтээ өгсөн боловч тус байгууллагаас 2023 он хүртэл</p> |
|--|--|--|--|--|--|--|--|--|--|

| | | | | | | | | | |
|---|--|---|-----------|---|----------|-----------------------------|----------------------------------|----------------------|--|
| | | | | | | | | | хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санал авсан, энэ онд дахин санал авахгүй тул уулзалт зохион байгуулах шаардлагагүй гэж мэдэгдсэн. |
| 8 | | 4.Увс аймгийн “Дэглий цагаан” нисэх буудлын хөөрч буух зурвасын хүчин чадлыг олон улсын 4С ангиллын болгох төслийг хэрэгжүүлнэ. | 2021-2023 | Улсын төсөв Зарцуулсан хөрөнгө 2020 он-2021 он: | 61,073.1 | ТЭЗҮ, зураг төсөл хийгдсэн. | Барилгын ажлын гүйцэтгэл 30 хувь | 18,321.9 40.000.0 | “Дэглий цагаан” нисэх буудлын хөөрч буух зурвасыг 451м-ээр уртасгаж өргөтгөх, хүчитгэхэд 61.1 тэрбум төгрөг шаардлагатай. Тус төслийг “Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад оруулах саналыг ЗТХЯ-ны 2021.05.20-ны өдрийн 03/2181 тоот албан бичгээр Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. “Дэглий цагаан” нисэх буудлын Зорчигч үйлчилгээний цогцолборын өргөтгөлийн ажлын зураг төслийг хүлээн авч, Барилгын хөгжлийн төвөөр хянуулахаар 2021.04.08-ны өдөр хүргүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад “Дэглий цагаан” нисэх нисэх буудлын хөөрч буух зурвасыг 451м-ээр уртасгаж өргөтгөх, хүчитгэх ажлыг тусгуулахаар саналаа 2021.05.10-ны өдрийн 01/699 албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн боловч Сангийн яам уг төслийг 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр байхгүй гэж үзэж хассан. Увс аймаг дахь нисэх буудлын зорчигч үйлчилгээний цогцолборыг цагт 300 зорчигч хүлээн авах хүчин чадалтай болгон өргөтгөх зураг төслийг боловсруулах гүйцэтгэгчээр “Нэйктслеп констрашн” ХХК 2020.10-р сард шалгарч, зураг төсвийг боловсруулж, энэ оны 4 дүгээр сарын 19-нд Барилгын хөгжлийн төвд хянуулахаар хүргүүлсэн боловч буцаагдсан. Төслийг зээл тусламж, концессын аль боломжит байдлаар хэрэгжүүлэхээр санхүүжилтийг эрэлхийлж байна. АХБ-ны Тээвэр, дэд бүтцийн зөвлөхтэй 2021.07.28-ны өдөр онлайнгаар |

| | | | | | | | | | |
|----|--|---|-----------|---|-------|---|---|-------|---|
| | | | | | | | | | уулзалт хийж, орон нутгийн нисэх буудлын хүчин чадлыг сайжруулах талаар баримталж буй бодлогыг танилцуулж, АХБ тус төслийг санхүүжүүлэх боломжийн талаар ярилцсан. Сангийн яамны холбогдох албан тушаалтнуудтай 2021.09.27-ны өдөр цахимаар уулзалт зохион байгуулахад Монгол Улс өрийн дээд хэмжээнд хүрсэн байгаа тул зээл авах боломжгүй талаар мэдэгдсэн. Уулзалтын үеэр олон улсын байгууллагуудаас санхүүжилт хүсэх, санхүүжүүлэх байгууллагуудаа өөрсдөө олохыг зөвлөсөн. Иймд уг зөвлөмжийн дагуу ЖАЙКА -тай уулзалт зохион байгуулах хүсэлтээ өгсөн боловч тус байгууллагаас 2023 он хүртэл хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санал авсан, энэ онд дахин санал авахгүй тул уулзалт зохион байгуулах шаардлагагүй гэж мэдэгдсэн. |
| 9 | | 5.Ховдын Булган, Хэнтий Дадал сумын нисэх буудлын аэродромд их засвар хийнэ | 2021-2022 | Улсын төсөв /өөрийн орлого/ Зарцуулсан хөрөнгө 2020 он-2021 он: | 900.0 | - | Ховд аймгийн Булган нисэх буудлуудын аэродромын их засварын ажлыг 100 хувь гүйцэтгэнэ | 600.0 | Хэнтий аймгийн Дадал сумын нисэх буудлын аэродромын их засварын ажлын тоо хэмжээг гаргаж, ажлын даалгаврыг баталж, ИНУТ-ийн өөрийн орлогоор санхүүжих 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд 715 сая төгрөгийг суулгаж, төлөвлөгөөний төслийг ЗТХЯ-нд хүргүүлсэн. Уг ажлыг хэрэгжүүлэх санхүүжилт шийдвэрлэгдээгүй тул 2021 онд хэрэгжих боломжгүй байна. |
| 10 | | 6.Баянхонгор нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвасын урсгал засвар | 2020-2021 | Улсын төсөв /өөрийн орлого/ Зарцуулсан хөрөнгө 2020 он-2021 он: | 980.0 | - | Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь | 980.0 | Баянхонгор нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвасын их засварын ажлын гүйцэтгэгчээр “Энигма констракшн” ХХК шалгарч, Иргэний нисэхийн ерөнхий газартай Ажил гүйцэтгэх тухай ИНЕГ/ХО/ТББ/Б-07/20-52/20 дугаартай гэрээг 2020 онд байгуулсан. Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2021.07.08-ны өдрийн А/255 дугаар тушаалаар “Энигма констракшн” ХХК-тай байгуулсан гэрээний хэрэгжилтийг үнэлэх, |

| | | | | | | | | | |
|----|--|--|-----------|--|---------|----------------------------|-----------------------------------|---------|---|
| | | | | | | | | | дүгнэх ажлын хэсгийг байгуулж, талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр 2021.08.16-ны өдөр нэмэлт гэрээ байгуулсан. Гэрээнд тусгасан нэмэлт өөрчлөлтийн дагуу гүйцэтгэгч нь гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 14 хоногийн дотор ажлыг эхлүүлж, 30 хоногт багтаан барилгын ажлыг дуусгаж, хүлээлгэж өгөхөөр байсан боловч гэрээний үүргээ биелээгүй тул гэрээ цуцлах хүсэлтээ ИНҮТ-ийн даргын 2021 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 10-1/1526 тоот албан бичгээр “Энигма констракшн” ХХК-д хүргүүлсэн. Мөн гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг цуцалж, мөнгөн төлбөрийг захиалагчийн дансанд төвлөрүүлэх тухай мэдэгдлийг Капитрон банкинд 2021.10.27-ны өдөр хүргүүлсэн. 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд уг ажлыг тусгахаар ажиллаж байна. |
| 11 | | 7.Хэнтий аймгийн "Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэн барих төсөл"-ийг хэрэгжүүлж дуусгана. | 2020-2022 | Гадаадын зээл, тусламж Зарцуулсан хөрөнгө 2020 он-2021 он: | 8,090.0 | Барилгын гүйцэтгэл 52 хувь | Барилгын ажлын гүйцэтгэл 80 хувь | 8,090.0 | Аэродромын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2021.10.15-ны өдрийн байдлаар 70%-тай . "Өндөрхаан нисэх онгоцны буудлыг шинэчлэн барих төсөл" Барилга Багц-1 төсөл арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийг 2021 оны 02 дугаар сарын 03 ны өдөр цахим системд зарласан бөгөөд Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2021 оны 3 дугаар сарын 01-ны өдрийн 128/ШЗ2021/1694 тоот захирамжаар тендерт оролцогч "Хар Чонот" ХХК-ийн гомдлыг шүүхээр эцэслэн шийдвэрлэх хүртэл түдгэлзүүлсэн. 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн дунд шатны шүүхийн хурлаар "Хар Чонот" ХХК-ийн талд шийдвэр гарсан. |
| 12 | | 8.Хэнтий аймгийн Дадал сумын Дэлүүнболдог | 2020-2021 | Улсын төсөв /өөрийн орлого/ | 5,000.0 | ТЭЗҮ, зураг төсөл | Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь | 5,000.0 | Дэлүүнболдог нисэх буудлын зорчигч үйлчилгээний цогцолбор барих гүйцэтгэгчээр "Биг монголиа билдинг" ХХК шалгарч, ЗТХЯ-тай "Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй |

| | | | | | | | | | |
|----|--|---|-----------|---|---------|---------------------------------|--------------------------------------|-------|--|
| | | нисэх буудлыг зорчигч үйлчилгээний цогцолбор шинээр барьж, дуусган ашиглалтад оруулна. | | Зарцуулсан хөрөнгө 2020 он-2021 он: | | хийгдсэн. | | | Дадал сумын “Дэлүүнболдог” нисэх буудлын барилга /Хэнтий, Дадал сум/ ажил гүйцэтгэх гэрээ”-г 2020.06.19-ний өдөр байгуулсан. 2021 оны улсын төсөвт зорчигч үйлчилгээний цогцолборыг барих санхүүжилт 5 тэрбум төгрөг тусгагдсан. Дэлүүнболдог нисэх буудлын зорчигч үйлчилгээний цогцолборын ажлын зураг төслийг БХТ-өөр хянуулж, 2021.03.20-нд хүлээн авсан. Барилга угсралтын ажлыг 2021.03.26-нд эхлүүлж, 2021.10.15-ны байдлаар 21.5%-ийн гүйцэтгэлтэй байна. |
| | 3. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орон нутгийн нисэх буудлуудын ашиглалтыг сайжруулна. | | | | | | | | |
| 13 | | 1. Орон нутгийн зорчигч тээврийн автобуудал, нисэх буудал, төмөр замын буудлын үйл ажиллагааг уялдуулж үр ашгийг дээшлүүлнэ. | 2021-2022 | Улсын төсөв /өөрийн орлого/ Зарцуулсан хөрөнгө 2020 он-2021 он: | | | Төслийг эхлүүлнэ | | Орон нутгийн зорчигч тээврийн автобуудал, нисэх буудал, төмөр замын үйл ажиллагааг уялдуулж үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр судалгаа хийж, 2021.07.27-ны 01/12111 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн. |
| 14 | | 2. Томоохон сум, суурин газруудад ерөнхий зориулалтын агаарын хөлгийн байнгын болон түр ажиллагаатай хөөрч буух зурвас, вертодром | 2020-2022 | Улсын төсөв /өөрийн орлого/ Зарцуулсан хөрөнгө 2020 он-2021 он: | 1,800.0 | 30 хөөрч буух зурвас баригдсан. | 30 хөөрч буух зурвас барьж дуусгана. | 600.0 | Зам, тээврийн хөгжлийн сайд, аймгийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээ 2021.03.12-ны өдөр байгуулсан. Тус гэрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Иргэний нисэхийн ерөнхий газартай хамтран шаардлагатай сумуудад Ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах агаарын хөлөг хөөрч, буух түр зурвасыг сонгон Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалтын дагуу орон нутгийн тусгай хэрэгцээний газарт авах үүрэг хүлээсэн. Аймгийн болон сумын засаг дарга нар ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах агаарын хөлөг хөөрч, буух түр зурваст |

| | | | | | | | | | |
|--|--|-----------------------|--|--|--|--|--|--|--|
| | | барих ажлыг эхлүүлнэ. | | | | | | | <p>хариуцагч томилон, байнгын арчлалт, хамгаалалт хийхэд гаргах зардлыг аймгийн төсөвт суулгаж, хариуцахаар гэрээнд тусгагдсан.</p> <p>Иргэний нисэхийн ерөнхий газрын 2021 оны төсөвт 3 байршилд бага оврын агаарын хөлгийн хөөрч буух зурвас байгуулах тэмдэг тэмдэглэгээний зардалд 52.260.000 төгрөг суулгаж, батлуулсан. Ховд аймгийн Чандмань, Өвөрхангай аймгийн Хужирт, Хөвсгөл аймгийн Цагаан нуур сумдад бага оврын агаарын хөлгийн хөөрч буух зурвас байгуулахаар 52,3 сая төгрөгийн санхүүжилтийг Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын 2021.03.26-ны өдрийн “Иргэний нисэхийн үндэсний төвийн 2021 оны орлого, зардлын төлөвлөгөөг батлах тухай” А/42/44 дугаар хамтарсан тушаалаар Иргэний нисэхийн үндэсний төвийн 2021 оны өөрийн орлогоос санхүүжүүлэхээр баталсан. Тус тэмдэг тэмдэглэгээг худалдан авах ажлыг тухай аймаг, орон нутгийн нисэх буудал хариуцан гүйцэтгэхээр шийдвэрлэсэн тул санхүүжилтийг Хөвсгөл, Өвөрхангай, Ховд аймгуудын нисэх буудлуудад шилжүүлсэн. Ховд аймгийн Чандмань, Өвөрхангай аймгийн Хужирт, Хөвсгөл аймгийн Цагаан нуур сумдад бага оврын агаарын хөлгийн хөөрч буух зурвасын тэмдэг тэмдэглэгээг байршуулж, баталгаажуулсан. 2011.10.10-ны байдлаар 61 байршилд хөөрч, буух зурвасын цэгийг сонгон хэмжилт хийж, координатыг баталгаажуулаад байна. Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хүчингүй болгосон тул хөтөлбөрийн хэрэгжилт зогссон.</p> |
|--|--|-----------------------|--|--|--|--|--|--|--|

| | | | | | | | | | |
|----|--|---|------|---|--|-------------------------------|----------------------|--|--|
| 15 | | 3.Улаан-баатар хотын шинэ нисэх онгоцны буудлын үйл ажиллагааг эхлүүлж, байнгын ашиглалтад оруулж, үйл ажиллагааг тогтворжуулсан байна. | 2021 | Улсын төсөв /өөрийн орлого/ Зарцуулсан хөрөнгө 2020 он-2021 он: | | Барилгын ажлын гүйцэтгэл 100% | Тогворжуулсан байна. | | “НУБИЭ” ХХК болон Япон Улсын Элчин сайдын яамнаас гаргасан хүсэлт, дотоодын агаарын тээвэрлэгчдийн санхүүгийн нөхцөл байдал, цар тахлын цаг үеийн нөхцөл байдал зэргээс шалтгаалан шинэ нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх товлосон хугацааг Засгийн газрын 2020.10.07-ны 134 дүгээр тогтоолоор 2021.07.01-ний өдрийн дотор эхлүүлэхээр хойшлуулсан. Шинэ нисэх буудлын үйл ажиллагаа 2021.07.03-ны өдрөөс эхэлсэн. |
|----|--|---|------|---|--|-------------------------------|----------------------|--|--|